



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/159/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 99092469 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас: 99026829 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn
Аудитор: Б.Эрдэнэтунгалаг
Утас: 99063931 Цахим хаяг: sain.audit5831@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	11
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3	Менежментийн захидал	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019-02-23 № 16/24
танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн бараа материалын дансанд бүртгэлтэй 71372,5 мянган төгрөгийн материалыг хагас жилээр болон жилийн эцсийн тайлан гаргахаас өмнө тоолоогүй нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 АУДИТЫН ТАЙЛАН

ОРШИЛ

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг газрын дарга Д. Цэндмаа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 р сарын 02-ноос 2018 оны 2-р сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сайн-Аудит ХХК-ын аудитор Б.Эрдэнэтунгалаг хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 38 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгох, ядуурлыг бууруулах, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг чанаржуулах, Монгол хүний амьдралын чанарыг сайжруулахад оршино. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ
- Нийгмийн халамжийн үйлчилгээ
- Ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын үйл ажиллагаа
- Улирлын шинжтэй Ахмадын сувилал

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд /Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардлын 1* хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсвийн хүрээнд зарцуулалт хийдэгтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны *Нийт зардал* 839158,0 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 8,391.58 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь дундаж хувьтай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Төлбөрийн акт тогтоосон	2	547.00	Урьдчилгаа дутуу суутгасан шатахуун зарцуулалт хэтэрсэн.
2	Албан шаардлага өгсөн	2	77,368.80	Бараа материал тоолоогүй
	Дүн	4	77,915.80	

2.1.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Санхүүгийн тайлангийн бараа материалын дансанд бүртгэлтэй 71372,5 мянган төгрөгийн материалыг хагас жилээр болон жилийн эцсийн тайлан гаргахаас өмнө тоолоогүй нь үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70,1,2 дахь заалт " түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1/ д хийх гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв

2.8.1.2 Байгууллагын ажилчдын сургалтын зардалд 2018 оны 12-р сарын 13 ны өдөр Вэст метиод ХХК руу 3500,0 мянган төгрөгийг гэрээ болон төлбөрийн баримтгүй шилжүүлсэн, мөн тухайн сургалттай холбоотой 3 өдрийн сургалтын хоолны зардлыг хэт өндөр үнээр тооцож 2496,3 мянган төгрөгийг шилжүүлсэн нь НББ-ийн тухай хуулийн 13-р зүйл, Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Зөрчлийг дахин давтахгүй байх тухай албан шаардлага өгөв.

2.8.1.3 Байгууллагын дарга Д.Цэндмаа нь албан ажлаар явсныг нотлох баримтгүй 397,0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 13 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Албан байгууллагын ажилд зарцуулаагүй 397,0 төгрөгийн шатахууныг үнийг дарга Д.Цэндмаагаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2.8.1.4 Ажилтан З.Батболдын 2018 оны 10-р сарын цалингийн урьдчилгааг 150,0 мянган төгрөгөөр дутуу суутгасан.нь үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламжийг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн:

Дутуу суутгасан 150,0 мянган төгрөгийн цалинг З.Батболдын цалингаас суутгаж төсвийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоов

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвийн мөнгийг үр ашигтай, удирдан зарцуулж буй эсэхийг хянаж шалгах

Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой нэг хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 669676,6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 662242,8 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь Асрамжид асруулж буй ахмадын тоо 21 хүнээр төсөв батлагдсан боловч тухайн оны эцэст 17 халамжлуулж байгаагаас шалтгаалжээ.

Төлөвлөгөөгөөр 23265.0 мянган төгрөг төвлөрүүлэх байснаас 32754.0 мянган төгрөг төвлөрүүлж, 140 хувиар давуулан биелүүлсэн байна

Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 80хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

- 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>69,232,003.70</u>	<u>74,164,393.60</u>
33	АВЛАГА	20,887,760.00	2,891,904.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,531,904.00	2,531,904.00
335	Бусад авлага	18,355,856.00	360,000.00
3351	Байгууллагаас авах авлага	18,355,856.00	360,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,344,243.70	71,272,489.60
351	Түүхий эд материал	254,835.00	187,760.00
35130	Эм боох материал	254,835.00	187,760.00
354	Хангамжийн материал	48,089,408.70	71,084,729.60
35410	Бичиг хэргийн материал	2,682,240.00	2,885,440.00
35420	Аж ахуйн материал	38,377,784.00	62,220,243.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	861,100.00
35440	Түлш, шатах тослох материал	2,445,204.70	3,722,686.40
35460	Хүнсний материал	4,584,180.00	1,395,260.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>422,958,516.83</u>	<u>974,615,439.06</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	422,958,516.83	974,615,439.06
392	Биет хөрөнгө	422,618,800.20	407,254,839.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	284,378,597.75	20,914,713.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	-186,108,447.69	15,409,221.69
39203	Авто-тээврийн хэрэгсэл	118,448,000.00	50,448,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-47,793,716.80	-20,715,873.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	294,757,757.86	338,222,926.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-156,672,128.31	-160,331,930.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	184,921,582.95	231,461,582.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	-69,312,845.56	-69,853,801.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,802,480.00	10,766,594.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,802,480.00	-9,066,594.00
393	Биет бус хөрөнгө	339,716.63	567,360,599.96
39303	Бусад биет бус хөрөнгө	374,000.00	567,398,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-34,283.37	-37,400.04
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>492,190,520.53</u>	<u>1,048,779,832.66</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,141,632.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,141,632.00	00.00
413	Өглөг	2,141,632.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,141,632.00	00.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>490,048,888.53</u>	<u>1,048,779,832.66</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	490,048,888.53	1,048,779,832.66

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	189,411,814.51	189,411,814.51
51101	Өмч: - төрийн	189,411,814.51	189,411,814.51
512	Хуримтлагдсан үр дүн	280,866,058.02	838,701,182.15
51210	Өмнөх үеийн үр дүн	280,866,058.02	280,866,058.02
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	557,835,124.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,771,016.00	20,666,836.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>492,190,520.53</u>	<u>1,048,779,832.66</u>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	806,167,531.80	1,396,993,456.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,556,160.80	733,567,456.00
120	Нийтлэг татварын бус орлого	58,556,160.80	733,567,456.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	58,556,160.80	733,567,456.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,439,000.00	32,754,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,117,160.80	700,813,456.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	747,611,371.00	663,426,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	619,234,900.00	646,411,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	619,234,900.00	646,411,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	128,376,471.00	17,014,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,181,000.00	16,879,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	135,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	807,582,032.02	738,036,657.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	807,582,032.02	738,036,657.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	697,814,624.20	687,505,753.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	407,604,830.48	431,360,357.01
210101	Үндсэн цалин	385,617,564.48	377,509,225.01
210102	Нэмэгдэл	9,117,346.00	42,230,632.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,216,700.00	11,620,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,126,387.91	55,386,906.00
210201	Тэтгэврийн даатгал	47,126,387.91	55,386,906.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,470,298.30	66,285,606.05
210301	Гэрэл, цахилгаан	4,841,282.00	4,960,151.00
210302	Түлш, халаалт	7,873,990.30	53,553,335.05
210303	Цэвэр, бохир ус	3,955,026.00	7,772,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	95,555,440.53	55,663,049.01
210401	Бичиг хэрэг	11,012,241.00	10,381,258.00
210402	Тээвэр, шатахуун	31,196,230.02	12,652,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,666,436.79	3,586,237.01
210404	Ном, хэвлэл	11,100.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,355,932.72	29,042,834.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	313,500.00	00.00
2105	Нормативт зардал	44,291,275.00	37,499,763.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	641,168.80	445,095.00
210502	Хоол, хүнс	37,422,172.00	37,054,668.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,227,934.20	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,690.00	1,071,030.00

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	710,000.00	6,700.00
210604	Урсгал засвар	7,182,690.00	1,064,330.00
2107	Томилолт, зочны зардал	1,400,800.00	906,400.00
210702	Дотоод албан томилолт	1,400,800.00	906,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,973,628.02	32,081,330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,752,428.02	29,342,680.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,602,000.00	2,079,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	619,200.00	587,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	50,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	21,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,499,273.96	7,251,311.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,495,500.00	354,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,250,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,753,773.96	6,897,311.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	109,767,407.82	50,530,903.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,400,000.00	19,774,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,200,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	19,774,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,200,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,623,196.82	30,756,103.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,623,196.82	30,756,103.23
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,744,211.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,744,211.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-1,414,500.22	658,956,798.92
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2593306.12	101121674.79
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,593,306.12	39,657,323.26
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	61,464,351.53
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,593,306.12	-101,121,674.79
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-4,007,806.34	557,835,124.13

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	791,305,198.00	722,362,733.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,818,086.00	32,754,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,818,086.00	32,754,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,818,086.00	32,754,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,439,000.00	32,754,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	4,379,086.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	757,487,112.00	689,608,733.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	619,234,900.00	646,411,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	619,234,900.00	646,411,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	128,376,471.00	35,370,256.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	93,195,471.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,181,000.00	35,235,256.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	135,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,875,741.00	7,826,877.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9,875,741.00	7,826,877.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	771,449,398.00	714,377,964.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	771,449,398.00	714,377,964.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	633,450,393.18	655,660,183.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	402,279,304.48	433,437,029.00
210101	Үндсэн цалин	380,292,038.48	379,666,897.00
210102	Нэмэгдэл	9,117,346.00	42,230,632.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,216,700.00	11,539,500.00

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210105	Гэрээт ажлын хөлс	6,653,220.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,341,122.91	54,064,661.00
210201	Тэтгэврийн даатгал	46,341,122.91	54,064,661.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,923,091.00	67,431,102.76
210301	Гэрэл, цахилгаан	4,841,282.00	4,960,151.00
210302	Түлш, халаалт	6,326,783.00	54,698,831.76
210303	Цэвэр, бохир ус	3,955,026.00	7,772,120.00
210304	Байрны түрээс	28,800,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,919,035.79	25,057,964.01
210401	Бичиг хэрэг	5,377,721.00	6,912,358.00
210402	Тээвэр, шатахуун	26,011,360.00	7,565,495.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,666,436.79	3,586,237.01
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,863,518.00	6,993,874.00
2105	Нормативт зардал	43,290,732.00	32,960,632.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	504,460.00	335,020.00
210502	Хоол, хүнс	37,422,172.00	31,170,112.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,364,100.00	1,455,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,866,931.00	4,096,915.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,978,700.00	1,059,990.00
210602	Тавилга	2,520,000.00	150,000.00
210604	Урсгал засвар	3,368,231.00	2,886,925.00
2107	Томилолт, зочны зардал	1,400,800.00	906,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,698,376.00	37,344,480.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,754,526.00	33,883,130.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,602,000.00	2,079,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	619,200.00	587,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	50,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	21,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	722,650.00	722,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,731,000.00	361,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	302,000.00	361,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,429,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,999,004.82	58,717,780.23

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	43,275,741.00	27,601,677.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9,875,741.00	7,826,877.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,200,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	19,774,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,200,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	71,979,052.82	31,116,103.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	71,979,052.82	31,116,103.23
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,744,211.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,744,211.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19,855,800.00</u>	<u>7,984,769.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,855,800.00	7,984,769.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,855,800.00	7,984,769.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,855,800.00	7,984,769.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	19,855,800.00	7,984,769.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-19,855,800.00</u>	<u>-7,984,769.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,411,814.5 1	19,771,016.0 0	280,904,705.36	490,087,535.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	3,969,159.00	3,969,159.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,411,814.5 1	19,771,016.0 0	284,873,864.36	494,056,694.87
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	19,771,016.0 0	63,212,718.91	82,983,734.91
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,411,814.5 1	19,771,016.0 0	280,866,058.02	490,048,888.53
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,411,814.5 1	19,771,016.0 0	280,866,058.02	490,048,888.53
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,411,814.5 1	19,771,016.0 0	280,866,058.02	490,048,888.53
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	895,820.00	00.00	895,820.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	557,835,124.13	557,835,124.13
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,411,814.5 1	20,666,836.0 0	838,701,182.15	1,048,779,832.6 6

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	669,676,600.00	662,242,856.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	669,676,600.00	662,242,856.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	649,901,800.00	642,468,056.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,538,100.00	433,437,029.00
210101	Үндсэн цалин	352,168,800.00	379,666,897.00
210102	Нэмэгдэл	64,276,400.00	42,230,632.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,092,900.00	11,539,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,064,700.00	54,064,661.00
210201	Тэтгэврийн даатгал	36,043,200.00	54,064,661.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,505,300.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,604,400.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	901,000.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,010,800.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,436,100.00	67,431,102.76
210301	Гэрэл, цахилгаан	14,252,600.00	4,960,151.00
210302	Түлш, халаалт	45,573,000.00	54,698,831.76
210303	Цэвэр, бохир ус	7,610,500.00	7,772,120.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,920,600.00	17,725,798.01
210401	Бичиг хэрэг	3,544,700.00	3,698,858.00
210402	Тээвэр, шатахуун	4,773,400.00	4,903,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,461,100.00	2,356,237.01
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,141,400.00	6,766,903.00
2105	Нормативт зардал	34,688,600.00	32,960,632.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	643,500.00	335,020.00
210502	Хоол, хүнс	30,402,200.00	31,170,112.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,642,900.00	1,455,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,271,700.00	8,726,684.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,724,700.00	5,839,759.00
210604	Урсгал засвар	5,547,000.00	2,886,925.00
2107	Томилолт, зочны зардал	1,247,000.00	868,200.00
210702	Дотоод албан томилолт	1,247,000.00	868,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,240,000.00	26,892,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,693,800.00	23,431,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,079,000.00	2,079,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	594,000.00	587,550.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,700.00	50,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21,800.00	21,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	722,700.00	722,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	495,000.00	361,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	495,000.00	361,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19774800.00	19774800.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,774,800.00	19,774,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,774,800.00	19,774,800.00

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	669,676,600.00	679,165,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	646,411,600.00	646,411,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	646,411,600.00	646,411,600.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	23,265,000.00	32,754,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,265,000.00	32,754,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.00	58,301.00
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00